



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 5/16

Хэрлэн сум

Д.Пүрэвжавыг түр орлон  
гүйцэтгэгчээр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- Хувийн ашиг сонирхлын удирдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл тогтоогдоогүй тул Доржийн Пүрэвжавыг 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.
- Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: С.Нямдаваа

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

Ц.Түвшинхүү

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудитор

С.Жав

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудитор

3. Д.Пүрэвжавд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг тооцож олгохыг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

4. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Д.Пүрэвжавд үүрэг болгосугай.

5. Д.Пүрэвжавд томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Ж.Гантулга)-т гаргаж өгөх үүрэгтэй сануулсугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ



• 231010426